

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд ард түмэн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан засгийн эрх барих эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт *“Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”* гэж заасан бөгөөд Хорин нэгдүгээр зүйлийн 1-д *“Улсын Их Хурал нэг танхимтай, 126 гишүүнтэй байна”* гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал нь ард түмнээс засгийн эрх барих эрх мэдлээ хэрэгжүүлдэг ард түмний төлөөлөгчдийн байгууллага билээ.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасанчлан Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхтэй. Улсын Их Хурлын тухай хуулийн 37.1-д Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хууль биелүүлэх үйл ажиллагаа болон Улсын Их Хуралд тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд чиглэдэг гэж заасан. Гэвч албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль зөрчсөн албан тушаалтанд хэрхэн хариуцлага хүлээлгэх зохицуулалт тодорхойгүй байгаа нь уг хуулийн төслийг санаачлах практик шаардлагыг үүсгэж байна.

2024 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д *“Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана”* гэж заасан боловч уг зохицуулалт дутуу орхигджээ. Үүний улмаас хууль зөрчсөн албан тушаалтнууд хариуцлагаас зайлсхийх, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг үл хүндэтгэх нөхцөл үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

Тиймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37.4 дэх хэсэгт Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг албан үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл уул албан тушаалтныг огцруулах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь гаргах эрхтэй байхаар хуулийн төсөл боловсруулсан.

Хуулийн төслийн үйлчлэлд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1.6-д заасан Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг дараах байгууллагууд хамаарна. Үүнд:

- Хүний эрхийн үндэсний комисс

- Санхүүгийн зохицуулах хороо
- Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөл
- Үндэсний аудитын газар
- Үндэсний статистикийн хороо
- Төрийн албаны зөвлөл
- Авлигатай тэмцэх газар
- Сонгуулийн ерөнхий хороо
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Шүүхийн сахилгын хороо
- Монгол банкны Ерөнхийлөгч
- Монгол банкны хяналтын зөвлөл
- Монгол банкны мөнгөний бодлогын хороо
- Олон нийтийн радио, телевиз
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл

Хуулийн төслөөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлд “37.4.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл огцруулах саналыг гаргах эрхтэй” гэсэн шинэ хэсэг нэмэхээр тусгасан.

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн нэрд “чөлөөлөх” гэсний дараа “огцруулах” гэж, 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт “чөлөөлөх” гэсний дараа “огцруулах” гэж, 111.2 дахь хэсэгт “чөлөөлөх” гэсний дараа “огцруулах” гэж, 111.3 дахь хэсэгт “чөлөөлөх” гэсний дараа “огцруулах” гэж тус тус нэмэхээр тусгасан. Мөн хуулийн төсөл нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр байхаар тусгасан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ